※ 번역문은 민원 신청을 위한 참고용이며, 기존의 한글 서식에 한글로 작성하여 제출해야 함을 유의해주시기 바랍니다.
※ Энэхүү орчуулга нь зөвхөн лавлах зориулалттай бөгөөд та солонгос хэл дээрх маягтыг зөвхөн солонгос хэлээр бөглөж ирүүлэх шаардлагатайг анхаарна уу.

외국인을 위한 지방세 납부 안내
Гадаадын иргэнд зориулсан орон нутгийн татвар төлөх заавар

- 외국인도 내국인과 마찬가지로 부동산, 자동차 등을 구입하거나 보유하면 그에 해당하는 지방세를 납부해야 합니다.
- **Гадаадын иргэн ч гэсэн дотоодын иргэний нэгэн адилаар үл хөдлөх хөрөнгө, автомашин зэргийг худалдан авах эсхүл эзэмшиж буй бол түүнд хамаарах орон нутгийн татварыг төлнө.**
- 여러분이 납부하는 지방세는 외국인의 정착 및 고용지원, 복지증대 등에도 사용됩니다.
- **Та бүхний төлж буй орон нутгийн татвар нь гадаадын иргэдийн суурьших болон ажил олголтыг дэмжих, халамжийг сайжруулах зэрэгт ашиглагдана.**

알아두면 도움되는 지방세 정보
Мэдэхэд илүүдэхгүй орон нутгийн татвартай холбоотой мэдээлэл

▸ 개인분 주민세

▸ Хувь хүний оршин суугчийн татвар

출입국관리법에 따라 외국인 등록을 하고 1년이 지난 경우 고지서 수령 후 개인분 주민세를 매년 8월에 납부해야 합니다.

Улсын хилээр орж гарах асуудал зохицуулах тухай хуулийн дагуу гадаадын иргэнийг бүртгэснээс хойш 1 жил өнгөрсөн бол нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш хувь хүний оршин суугчийн татварыг жил бүрийн 8 сард төлнө.

▸ 자동차세

▸ Авто тээврийн хэрэгслийн татвар

자동차를 소유하고 있는 경우 거주지 등록지에서 고지서 수령 후 매년 6월, 12월 자동차세를 납부해야 합니다.

Авто тээврийн хэрэгсэл эзэмшиж буй бол оршин суугаа хаягийн бүртгэл дээрээ нэхэмжлэл хүлээн авсны дараа жил бүрийн 6 сар, 12 сард авто тээврийн хэрэгслийн татварыг төлнө.

▸ 재산세

▸ Хөрөнгийн татвар

부동산(건축물, 토지, 주택 등)을 소유하고 있는 경우 매년 7월, 9월에 재산세를 납부해야 합니다.

Үл хөдлөх хөрөнгө (Барилга, газар, орон сууц гэх мэт)-г эзэмшдэг бол жил бүр 7 сар, 9 сард хөрөнгийн татвар төлнө.

▸ 취득세

▸ Хөрөнгө эзэмших татвар

부동산, 자동차 등을 취득할 경우 60일 이내에 취득세를 신고·납부해야 합니다.

Үл хөдлөх хөрөнгө, авто тээврийн хэрэгсэл гэх мэтийг худалдан авах,эзэмших бол 60 хоногийн дотор хөрөнгө эзэмших татварыг мэдүүлж, төлнө.

▸ 지방소득세

▸ Орон нутгийн орлогын албан татвар

소득세법에 따른 소득세 납세의무자(개인) 및 법인세법에 따른 법인세 납세의무자(법인)의 경우 소득에 대해 지방소득세(개인·법인)를 신고· 납부해야 합니다.

Орлогын албан татварын хуульд заасан орлогын албан татвар төлөх үүрэг бүхий эдгээд (хувь хүн) болон хуулийн этгээдийн татварын тухай хуульд заасан хуулийн этгээдийн татвар төлөгч (хуулийн этгээд)-ийн хувьд олж буй орлогод хамаарах орон нутгийн орлогын албан татвар (хувь хүн болон хуулийн этгээд)-г мэдэгдэн бүртгүүлж, татварыг төлөх шаардлагатай.

간편하고 편리한 지방세 납부 방법

Орон нутгийн татвар төлөх хялбар арга

▸ 인터넷 납부

▸ Интернетээр төлөх

위택스(www.wetax.go.kr), 인터넷 뱅킹으로 납부

Wetax (www.wetax.go.kr) сайт, интернет банкаар төлөх

※ 회원가입 및 로그인→공인인증서 등록→조회납부

※ Гишүүнээр элсэх ба Нэвтэрч орох→Хувийн баталгаажуулалт хийх→Татвар төлөх

▸ 모바일 납부

▸ Гар утсаар төлөх

카카오페이, 네이버페이, 페이코에서 고지서 QR코드 스캔하여 납부

Kakao, Naverpay, Payco ашиглан мэдэгдэл дээрх QR код уншуулж төлөх

▸ 은행에서 납부

▸ Банкаар төлөх

고지서로 전국 모든 은행에서 납부

Нэхэмжлэлийн дагуу аль ч банкийг ашиглан төлөх боломжтой

고지서가 없어도 신용(체크)카드, 통장, CD/ATM 기기로 납부

Нэхэмжлэл байхгүй ч кредит (чек) карт, банкны дэвтэр, CD/ATM-ээр төлөх боломжтой

지방세를 납부하지 않으면 여러 가지 불이익을 받게 됩니다

Орон нутгийн татвар төлөөгүй бол олон талын сөрөг үр дагавар үүсэж болзошгүй.

▸ 비자연장 제한

▸ Визийн сунгалтыг хязгаарлах

지방세를 체납할 경우 비자연장이 제한됩니다.(6개월 이하만 허가)

Орон нутгийн татвараа хугацаанд нь төлөөгүй бол визийн сунгалтыг хязгаарлана.(зөвхөн 6 сараас доош хугацаагаар олгоно)

▸ 재산, 채권 압류

▸ Эд хөрөнгө, бонд битүүмжлэх

차량, 부동산, 예금, 급여, 보험(출국만기보험, 귀국비용보험) 등이 압류될 수 있습니다.

Авто тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, хадгаламж, цалин, даатгал (улсын хилээр гарахад дуусгавар болох хугацаатай даатгал, эх орондоо буцах зардлын даатгал) зэрэг нь битүүмжлэгдэж болзошгүй.

▸ 공매 처분

▸ Олон нийтийн нээлттэй дуудлага худалдаагаар зарж борлуулах

소유하신 차량, 부동산 등이 공매 처분될 수 있습니다.

Эзэмшиж байсан автомашин, үл хөдлөх хөрөнгө зэргийг олон нийтийн нээлттэй дуудлага худалдаагаар зарж борлуулах хүртэл арга хэмжээ авч болзошгүй.

▸ 자동차번호판 영치

▸ Автомашины дугаарыг битүүмжлэх

자동차세 미납 시 자동차번호판이 영치되어 운행이 제한될 수 있습니다.

Авто тээврийн хэрэгслийн татвараа төлөөгүй тохиолдолд автомашины дугаарыг битүүмжлэн замын хөдөлгөөнд оролцохыг хязгаарлана.